

үндэстэн бүр уусаж нэгдэх биш харин хөгжин бадарч байх хамтын цэцэглэлтийн үе гэсэн ойлголтыг дэвшүүлсэн байна.

Мөн хятад биш үндэстнүүд өөрсдийн өөртөө засах эрхийг эдэлж хэрэглэх явдлыг хуульчлан журамлаж, хууль ёсны баталгаатай болгох талаар тодорхой зарим арга хэмжээ авчээ. Энэ нь урьд өмнө «их үсрэлт», «соёлын хувьсгал» зэрэг улс төрийн кампанит хөдөлгөөний үед хятад биш ард түмний өөртөө засах эрх мэдлийг дур зоргоор зөрчиж байсан тийм адал балмад явдлыг дахин гаргуулахгүй байх зорилготой бололтой.

1. Үндэстний районы өөртөө засах бодлого гэдэг нь аливаа үндэстэн салан тусгаарлаж тусдаа улс байгуулах хүртэл эрхтэй үндэстний өөртөө засах тохинох бодлогоос ялгаатай бөгөөд тухайн үндэстний төвлөрөн суудаг районд хэрэгжүүлэх үндэстний орон нутгийн автономийг хэлнэ.

2. XII Всекитайский съезд Коммунистической партии Китая (документы), Пекин, 1982, с. 54

3. КНР. Конституция в законодательные акты М., 1984, с. 24

4 КНР. Конституция и законодательные акт. М., 1984, с. 52

5. «Жэньминь жибао» 1984. 06. 04

6. Основные нормативные акты о местных органах государственной власти и государственного управления КНР М., 1956, с. 66

7. В. А. Богословский. Политика «единого фронта» в Тибете. «Проблемы Дальнего Востока», 1981. No 2, с. 86—87

8. «Жэньминь жибао» 1984. 06. 04

9. «Жэньминь жибао» 1984. 05. 25

10. «Миьцзу туаньцзе», 1985, No 11

11. «Жэньминь жибао» 1981. 10. 05

12. Бодит тэгш бус байдал гэдэг нь хуулиар батлагдсан үндэстний хоорондын улс төрийн тэгш эрхийг биш, харин жинхэнэ амьдрал дээр тэдний хооронд оршиж буй эдийн засаг-соёлын тэгш бус байдлыг хэлнэ.

13. «Чжунянь миьцзу сюэюань сюэбао, 1986. No 1, с. 3—8

14. Е. Г. Гельбрас. Социально-экономические аспекты национального строительства в КНР. «Рабочий класс и современный мир», 1984. No 2, с. 78

15. Миьцзу яньцзю» 1986 No 1, с. 46—47

16. Мөн тэнд

17. «Жэньминь жибао» 1987. 05. 28

18. «Миьцзу туаньцзе» 1987. No 9, с. 5

19. «Жэньминь жибао» 1987. 11. 04

## ХЯТАДЫН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ЭРГЭЛТИЙН ҮЕ

(ХКН-ын ТХ-ны 1978 оны III бүгд хурлын 10 жилийн ойд)

Д. БАЯСГАЛАН

ХКН-ын болон Хятад орны амьдралд түүхэн ач холбогдол бүхий ХКН-ын ТХ-ны 1978 оны III бүгд хурал нь урьд өмнөх бүгд хурлуудаас олон талаар ялгаатай болсон юм. Тухайлбал, Бүгд хурал хятад орны эдийн засгийг хөгжүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлж, хятадын удирдлагаас баримталж байсан зарим нэгэн алдаатай бодлогыг тодорхойлон дүгнэжээ. Бүгд хурлыг хуралдуулахын өмнө Хятадын бүх мужийн

намын хорооны байнгын товчооны өргөтгөсөн хуралдааныг зохиож Линь Био болон «4-н бүлгийг» илчлэх кампаны дүнг болон тухайн үед эдийн засгийг хөгжүүлэх тодорхой зорилтуудыг хэлэлцсэн байв.

ХКН-ын Төв Хорооны III бүгд хурал 1978 оны 12-р сарын 18—22-нд Бээжинд хуралдаж, хятадын эдийн засгийн үндсэн салбарт гарсан зарим амжилтыг тэмдэглээд, Масист бодлогын уршгаар учирсан эдийн засгийн ноцтой бэрхшээлийг даван туулах, улмаар «Дөрвөн шинэчлэлтийн программ»-ыг улам боловсронгуй болгон өөрчлөх гол асуудлыг хэлэлцжээ. Бүгд хурлаас Хятад орны эдийн засагт ноёрхож байсан үйлдвэрлэл, хэрэглээний хоорондын тэнцвэргүй байдал, худалдаа, хуваарилалтын салбар дахь эмх замбараагүй байдлыг арилган, улс орноо эдийн засгийн хүнд байдлаас гаргахын тулд чухал шийдвэрүүдийг гаргажээ. Үүнд: Үйлдвэрлэлийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх нь зайлшгүйн тухай, эдийн засгийн шинэтгэлийн бодлогын тогтоцыг үүсгэх, эдийн засгийг удирдах аж ахуйн аргад гүн гүнзгий өөрчлөлт хийх заалт өгчээ. Хятадын хөдөө аж ахуйн хөгжлийг хурдасгах асуудал бүгд хурлын анхаарлын төвд байлаа. Бүгд хурал хятадын хот, хөдөөгийн ард иргэдийн амьдралд олон жил хуримтлагдсан хүнд бэрх байдлыг бодитойгоор хүлээн зөвшөөрч, шинэчлэлийн программыг хэрэгжүүлэхдээ ХАА-н үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний ашиг шимийг нэмэгдүүлэн, хүн амын амьдралын нөхцөлийг сайжруулах нь зайлшгүй байгаа тухай бүгд хурлын баримт бичигт онцлон тэмдэглэжээ. Иймээс ч, бүгд хурал аж ахуйн асуудлыг «өнгөрснөөс үлдсэн чухал асуудлуудын нэгэн» гэж онцлон заажээ.

Мөн тус бүгд хурал дээр Маогийн жижиг хөрөнгөтний балмад чиг бодлогыг ХКН-ын Лушаны бүгд хурал (1959 он) дээр зоригтойгоор шүүмжилсэн хятадын хувьсгалын баатар Батлан хамгаалах яамны сайд агсан Пэн-Дэхуайг цагаатгасан нь олон нийтийн анхаарлыг ихэд татсан юм. Пэн-Дэхуайн хамт ХКН-ын бас бус нэрт зүтгэлтэн, Гао Жу, Бо Ибо, Ян-Шанькунь зэрэг «соёлын хувьсгал»-ын үед хэлмэгдэгчдийг цагаатгажээ. Ийнхүү 50-иад оны нам, төрийн зүтгэлтнүүдийг цагаатган, дахин гаргаж ирсэн нь цаашид зарим нэгэн хэрэг явдал цагаатахад чухал алхам болсон юм. 1976 оны 4-р сарын Тяньаньмэний талбай дахь хэрэг явдлыг урьд нь «хувьсгалын эсэргүү будлиан» мэтээр үзэж байсныг буруушааж энэ нь олон түмний хувьсгалт хөдөлгөөн гэж үзсэн байна. Ингэснээр 2 жил үргэлжилсэн «Линь Бяо ба 4-н бүлгийг» илчлэн шүүмжлэх олон нийтийн кампани хөдөлгөөн дууссаныг зарлаж намын ажлын гольтрогийг «дөрвөн шинэчлэлтийн программыг хэрэгжүүлэхэд» шилжүүлэхийг заажээ. Мөн ардчилал, хууль ёсыг хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж, намын доторхи ардчилсан төвлөн удирдах ёс ба намын амьдралын хэм хэмжээг эрүүлжүүлэх», намын нийт бүрэлдэхүүнийг «сайжруулах», намын сахилга батыг бэхжүүлэх нь чухал байгааг заагаад нэг чухал зорилтоо болгосон юм. Сахилга батыг шалган байцаах төв комиссыг 100 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж даргаар нь Чэнь Юнь-г сонгожээ.

Бүгд хурлын албан ёсны мэдээнд Маогийн алдааг тойруугаар хүлээж, тэр үед хийгдсэн ямар ч алдаа нь түүний «өндөр нэр төрийг унагахгүй юм» гэж үзсэн юм. Гэвч бүгд хурлын шийдвэрийн үндсэн агуулга нь Хятадын хөгжлийн тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийж Хятад орны улс төр, нийгэм-эдийн засгийн амьдралын бүх хүрээнд гүн гүнзгий шинэчлэл хийх бодлогыг анх дэвшүүлснээрээ чухал ач хол богдолтой болсон юм.

1987 онд хуралдсан ХКН-ын XIII их хурал, 1978 оны энэхүү бүгд хурлаас хойшхи шинэчлэлтийн 9 жилийн дүнг гаргаж, улмаар БНХАУ социалист бүтээн байгуулалтын замаар гуйвалтгүй замнах болон улс орноо хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвийг тодорхойлсон юм. Их хурал хуралдахаас өмнө Хятадын хэвлэлүүдэд 1976 оны сүүлчээс хойшхи шинэчлэлийн бүхэл бүтэн цогц, нарийн асуудлуудыг хөндсөн шүүмжлэн хэлэлцэх ажил өрнөсөн юм. Энэ ажлын дүнг XIII их хурлаас нэгтгэн дүгнэлээ.

Нэг дэх үе нь: (1976 оны 10-р сараас 1978 оны 12-р сар) Улс төрийн хурцадмал, зөрөлдөөнтэй байдлаараа илүү онцлогтой энэ үед онол, үзэл суртал, улс төр, зохион байгуулалтын сэдвүүдээр хурц маргаан өрнөж, Хятадын ард түмний амьдралд «Их үсрэлт», «Соёлын хувьсгал»-ын авчирсан гай гамшгийг харуулсан материалууд хэвлэлд нийтлэгдэж байв. Тухайлбал У Зиньянь, Линь Цижу, Би Юньин нарын бичсэн «Дөрвөн бүлгийнхний социал-фашист номлолыг шүүмжлэх нь», Ван Бинь ба Лю-Ючэний бичсэн «Ардчилсан амьдрал дахь хазайлтын тухай асуудалд» гэх мэт өгүүлэлүүдийг нэрлэж болох юм.

Хоёр дахь үе нь: (1978 оны 12-р сараас 1981 оны 6-р сар) Энэ үед Шүүмжлэн хэлэлцэх явдлыг зөөлөн аястай болгожээ. 1978 оны II бүгд хурал, тэр үед шинэчлэлтийн мөн чанар бүрэн тодроогүй байсан учраас «өргөн, гүн гүнзгий хувьсгал» гэж шинэчлэлийг томъёолж, эдийн засаг дахь хуучны үлдэгдэл, уршгийг гэтлэн давж, үндсэн хямралыг түргэн арилгах явдал хойшлуулшгүй, тодорхой зорилт болохыг тодорхойлсноороо Хятадын нийгмийн хөгжлийн чухал асуудлуудад өргөн цар хүрээтэй хандах явдалд хүчирхэг түлхэц болсон юм.

1979 онд ХКН-ын Төв Хороо «зохицуулах, өөрчлөх, цэгцлэх, дээшлүүлэх» чигийг анх тунхаглажээ. 1980 оны 12-р сарын 2-ны «Жэньминь жибао» сонин редакцийн өгүүлэлдээ, уг чиг шугамаас хамгийн гол нь «Зохицуулах» явдал гэдгийг онцлон тэмдэглэжээ. 1982 онд хуралдсан ХКН-ын XII их хурлаас «зохицуулалтын» зааг нь 1985 оныг хүртэл гэж үзсэн ба энэ үеийн өөрчлөлт шинэчлэлт нь «зохицуулалтын» эрх ашигт бүрэн нийцсэнээрээ ирээдүйн өөрчлөлтөд бодит алхам болсон юм. ХКН-ын Төв Хорооны 1979 оны IV бүгд хурал дээр Е Зяньины тавьсан илтгэлд «... Манай улс хөгжиж байгаа социалист орон хэвээр байна. Эдийн засаг, соёл хөгжингүй болоогүй байгаа ч манай социалист байгуулал хөгжлийнхөө үе шат бүхэнд бэрхшээлийг даван туулсаар эцэстээ орчин үеийн капиталист нийгмийн үйлдвэрлэх хүчний түвшингээс өндөрт гарах юм»<sup>1</sup> гэжээ. Энэ санаа нь ХКН-ын XII их хурлын үзэл санааны гол сурвалж болж өгчээ.

ХКН-ын XIII их хурлаас тодорхойлсон «социализмын эхэн шатны» ойлголтыг анх 1981 оны ХКН-ын Төв Хорооны VI бүгд хурал дэвшүүлжээ. Энэ үед Хятадын олон эрдэмтэд бусад социалист орнууд дахь социалист байгуулалтын туршлагыг нягтлан судалж, өөрийн оронд социализм байгуулах шинэ, өвөрмөц санаагаа бүрдүүлэх иж бүрэн, цогц асуудлуудыг боловсруулсан ба 1979—1981 онуудад тухайн сэдвээр шинжлэх ухааны хэлэлцүүлэг ихээхэн өрнөж, шинжилгээ судалгааны бүтээлүүд, эрс олширсон юм. Үүнд, Су Шаожи, Фэнь Ланьшуй, Жу Шусянь, Лю Зяньсинь, Жан Кай нарын өгүүлэл орох ба тэдгээрт, хятадын нийгэм эдийн засгийн хөгжилд бодит дүгнэлт өгч шилжилтийн үеийн ба социалист байгуулалтын асуудлыг боловсруулахад зохих хувь нэмэр болохуйц санаа өгсөн байна. Шүүмжлэн хэлэлцэх олон янзын чиглэлүүд гарч ирсэн ч олонхи эрдэмтэд, хувьсгалын өмнөх Хятад орон капиталист хөгжлийн үе шатыг дайрч өнгөрөөгүй ба харин ч Хятадад социализм хөгжих угтвар

материаллаг нөхцөл байсан. Иймээс Хятад улсын хувьд юуны өмнө феодалын үлдэгдэл, хоцрогдлыг даван туулах, капитализмын «нэмэлт бяцхан зөргөөр» өнгөрөх зорилт тулгарсан юм гэсэн санааг гаргажээ.

Гурав дахь үе нь: (1981 оны 6-р сараас 1987 оны 11-р сарыг хүртэл буюу ХКН-ын XIII их хурлын дараах үе) Энэ үед хуралдсан VI бүгд хурал Маогийн үйл ажиллагаанд гарч байсан онол практикийн алдаа завхрал, ололт дутагдлыг харьцуулан дүгнэсэн юм. 1982 онд хуралдсан ХКН-ын XII их хурлыг нээж хэлсэн үгэндээ Дэн Сяопин ХКН-ын VIII их хурлын шийдвэрийг үнэлсэн ба улмаар «Марксизмын сургаалын түгээмэл үнэнийг хятадын тодорхой практиктай холбосноороо бидний зорилго нь-Хятадын онцлогтой социализмыг байгуулах явдал болох бөгөөд энэ нь бидний туулж ирсэн замын түүхэн туршлагыг нэгтгэн гаргах үндсэн үр дүн болох юм»<sup>2</sup> гэх хэлсэн юм.

V бүгд хурал болон XII их хурлын шийдвэрүүдэд 60—70-аад оны үе дэх улс оронд хуримтлагдсан үйлдвэрлэлийн харилцааны мөн чанарын тухай асуудал, 80-аад оны эхэн үеийн нийгэм эдийн засгийн хөгжлийн үе шатны асуудал аль алиныг нь төдийлөн тусгасангүй. Харин 1984 оны бүгд хурлаас «эдийн засгийн системд шинэтгэл хийх» тухай тогтоол гаргасан ба түүнд эдийн засгийг хөгжүүлэх, хятадын өвөрмөц онцлогтой тохирсон социализм байгуулах тухай заажээ. Уг тогтоолд, эдийн засгийн системийн шинэтгэлийг гол төлөв хөдөө нутагт хэрэгжүүлснийг тэмдэглээд, цаашид шинэтгэлийг хотод хэрэгжүүлэх хурдацыг түргэтгэх зорилт тавьсаныг дурджээ.

Тогтоолд, хотууд дахь эдийн засгийн шинэтгэлийн гол нь үйлдвэрийн газруудыг аж ахуйн биеэ даасан байгууллага болгож төлөвлөгөөгөөр удирдах системийн хүрээг багасгах таваарын харилцааг бүх талаар хөгжүүлэх явдал<sup>3</sup> гээд гадаад орнуудтай харилцах эдийн засгийн харилцааны гол чиглэл болох «нээлттэй хаалгын» бодлого нь төрийн урт хугацааны бодлого бөгөөд практикт үр дүнгээ өгч байна<sup>4</sup> гэж тэмдэглэжээ. Уг тогтоолын үндсэн дээр нээлттэй хаалгын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд хятадад «эдийн засгийн тусгай бүс» дөрвийг байгуулж, Шанхай, Гуанчжоу зэрэг тэнгэсийн эрэг орчмын 14 хотыг нээлттэй хот гэн зарлан тэдгээрт гадаадын капитал чөлөөтэй нэвтрүүлэх болжээ.

VI бүгд хурал 1966-1976 онуудыг «БНХАУ байгуулагдсанаас хойшхи ноцтой алдаа дутагдал»-ын 10 жил гэж үзсэн ч энэ үеийг хятадын орчин үеийн нийгмийн хөгжлийн нэгэн социалист үе шат гэжээ. Цааш нь хятад орны социализмд шилжих шилжилтийн үе 1956 онд дууссан гээд одоо социализмын эхэн шатанд оршиж байна гэж дүгнэжээ.

ХКН-ын XIII их хурал хятадын социализмын эхэн шат нь 100 жил үргэлжилнэ гэж заав. Хятадын социализм нь хөгжлийн түүхэн онцлогтой урт хугацааг агуулж байгаа нь ч сүүлийн жилүүдэд тодорхой боллоо. Үүнээс үүдэн, социализмын эхэн шатны тухай үзэл санаа гарч ирж байна. Социализмын эхэн шатанд эдийн засгийн хөгжлийн стратегийг тодорхой болгон хөгжүүлэхэд 3 үеийг туулах юм. I үед буюу 80-аад онуудад үндэсний нийт бүтээгдэхүүн 80 оныхоос 2 дахин нэмэгдэж, ард түмнийг «гэдэс цатгалан, хувцас дулаан» явуулах болно. Энэ асуудал одоо хятадад «үндсэндээ» шийдэгджээ. Үүний гол хэрэгжилт нь «өлсгөлөн, хувцасгүйдлээс» чөлөөлөгдсөн явдал юм. Энэ үеийн төгсөлт нь БНХАУ-ын төрийн зөвлөлөөс 1987 оны 11-р сард гаргасан «Ядуу районууд дахь эдийн засгийн ажлыг дээшлүүлэх тухай» тогтоолын хэрэгжилт байх юм. II үе нь 90-ээд онд ард түмний «энгийн дутагдлыг» арилгах

явдал гэж үзэж байна. III үе нь XXI зууны дунд үед шинэчлэлт, өөрчлөлтийн программаа биелүүлж, дунд зэргийн хөгжилтэй орны түвшинд хүргэж, ард түмнийг чинээлэг аж байдлаар хангах нь энэ үеийн түүхэн шинж юм гэж үзэж байна. Мөн, эдгээр үе шат бүхэнд Хятадын нийгэм эдийн засаг болон анги, давхарга, бүлэг бүхэн өөрийн гэсэн онцлог төрхтэй байх ба энэ программын эхэнд гурван зангилаа асуудал болох шинжлэх ухаан, техник, ардын боловсролыг хөгжүүлэх явдлыг эрчимжүүлэх болно гэж үзэж байна.

ХКН-ын XIII их хурлын баримт бичгээс үзвэл 1978 оны III бүгд хурлаас хойшхи 9 жилд БНХАУ-ын нийгмийн үйлдвэрлэл, улсын санхүүгийн орлого, хот, хөдөөгийн хөдөлмөрчдийн дундаж орлого 2 дахин нэмэгдсэн ба 2000 он гэхэд түүнийг 2 дахин өсгөх бололцоотой болох ажээ.

Хятад улс эдийн засгийн зарим гол үзүүлэлтүүдээр өнөөдөр дэлхийн түвшинд ойртож очсоныг эдийн засагт шинэчлэлтийн бодлогыг тууштай хэрэгжүүлсэн, гадаад эдийн засгийн харилцааг өргөтгөсөн явдлаар тайлбарлаж байна.

ХКН-ын XIII их хурлын тайлан илтгэлд 1978 оны III бүгд хурлын дараахь 9 жилд БНХАУ байгуулагдсанаас хойш социалист байгуулалтын талаар олон их амжилтын үндсэн дээр намын түүхэн хөгжилд шинэ үе шатыг нээж, улс орны дүр төрхөд гүнзгий хувиралт гаргасан марксист зөв чиг шугамын ялалт байсныг тэмдэглэжээ. Мөн, марксизм хятадын хөгжлийн практиктай уялдан 60 гаруй жил болоход 2 удаа түүхэн чанартай үсрэлт хийсний нэг дэх нь хятадын онцлогтой хувсгалыг ялалтад хүргэсэн явдал, хоёрдахь нь 1978 оны III бүгд хурлаас хойш хятадын өвөрмөц онцлогтой социализм байгуулах замыг сонгон олж, социалист бүтээн байгуулалтын шинэ үе шатыг нээсэн юм гэж тус бүгд хурлыг онцлон үзсэн билээ. Энэхүү бүгд хурлаас эх авсан үзэл санаагаар БНХАУ «Дөрвөн шинэчлэлтийн» үйл явцаар нэн сонирхолтой, олон талаар үр бүтээлтэй үзэл санааг хэрэгжүүлж байгаа тухай М. С. Горбачев «өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ...» номдоо дурджээ<sup>5</sup>.

Энэхүү бүгд хурлаас хойшхи үед Хятадын өвөрмөц онцлогтой социализмыг байгуулах замд учирч байгаа онол-практикийн олон шинэ асуудалд шинжлэх ухааны социализмын үүднээс оновчтой хариулт өгөх оролдлого, санаачлагууд өрнөж ирснийг тэмдэглэвэл зохино. Өөрөөр хэлбэл, өнөөгийн хятад орны нөхцөлд тохируулан социализмын давуу талыг нь аль болох бүрэн нээн илрүүлэх, үйлдвэрлэх хүчний хөгжлийг оновчтой түргэн хөгжүүлэх, ард түмний сайн сайхан амьдралын нөхцөлийг хангах зэрэг улс орныхоо хөгжлийн стратегийн чиг шугамыг тодорхойлж өгсөнд III бүгд хурлын түүхэн ач холбогдол оршино.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН НЭРС

1. «Жэньминь Шибao» 1979. 9. 29
2. ХКН-ын XII их хурлын материал. «Жэньминь Жибао» 1987. 10. 26
3. Жэньминь жиба» 1984. 10. 21
4. Мөн тэнд
5. М. С. Горбачев, өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ, УБ., 1988. 207-р тал